



МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2011 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр болж ажлын төлөвлөгөөний дагуу Монголбанкны гадаад активын байршил, үр дүн, Монголбанкны 2010 оны ашиг хуваарилалт, нөөцийн сангийн байдал болон Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх асуудалтай танилцсан дүнг тус тус хэлэлцсэн байна.

Хяналтын зөвлөл гадаад валютын нөөцийн аюулгүй байдлыг хангахад Монголбанкны валютын нөөцийн удирдлага бүрэн чиглэж, банкны тухай хууль, эрх зүйн бусад актад заасан шаардлагын дагуу зохистой явагдаж буй эсэхэд тогтмол хяналт тавьж байна.

Монголбанкны гадаад валютын улсын нөөц 2011 оны эхний хагас жилд 253.6 сая ам. доллараар нэмэгдэж, 2 541.4 сая ам. долларт хүрсэн нь улс орны импортын 23.6 долоо хоногийн хэрэгцээг хангаж байна. Валютын нөөц сүүлийн жилд тогтмол өсч байгаа хэдий ч Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үндсэн чиглэлд заасан шаардлагын хэмжээг бүрэн хангаж чадаагүй байгааг Хяналтын зөвлөлөөс тэмдэглэв.

Монголбанк форвард арилжаагаар валют худалдан авч байснаа зогсоосон нь Монголбанкны хүлээх санхүүгийн эрсдэлд хэрхэн нөлөөлөх талаар эерэг, сөрөг үр дагаврыг багтаасан дэлгэрэнгүй нэмэлт тайлбар мэдээлэл болон Хяналтын зөвлөлөөр удаа дараа яригдсан гадаад валютын улсын нөөцийг ямар төвшинд хүргэх, валютын нөөцийн талаарх мэдээллийг ямар үзүүлэлтээр хэрхэн ил тод болгох тухай асуудлыг олон улсын туршлагад үндэслэн гаргасан дэлгэрэнгүй танилцуулгыг 2011 оны 3 дугаар улиралд багтаан гаргаж Хяналтын зөвлөлд ирүүлэхийг Монголбанкны удирдлагад зөвлөмж болгосон байна.

Монголбанкны 2010 оны ашгийн хуваарилалт, нөөцийн сангийн байдалтай танилцаад Монголбанк 2010 онд 145,5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласны 72.8 хувь нь валютын ханшийн зөрүүг нөхөх, 25.8 хувь нь инфляцийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаанаас хамаарсан байна гэдгийг тэмдэглээд Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 38¹ дүгээр зүйлийг үндэслэн Монголбанкны 2010 оны алдагдлыг нөхөх, эсэх асуудлыг Улсын Их Хуралд оруулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Манай улс шинэ мөнгөн дэвсгэртийг 1993 оноос гүйлгээнд гаргаж эхэлжээ. Өдгөө 1, 5, 10, 20, 50, 100, 500, 1000, 5000, 10000 болон 20000-тын дэвсгэрт гүйлгээнд байна. Монголбанк нь 2009 оны сүүлчээс мөнгөн дэвсгэртийн мэдээллийн сангийн программ боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхэлсэн байна. Одоогоор энэ ажил эхлэлийн төдий байгаа бөгөөд цаашид жигдэрч чадвал мөнгөн дэвсгэртийн үйлдвэрлүүлсэн тоо хэмжээ, гүйлгээнд гаргасан, эргэж орж ирсэн болон устгасантай холбоотой мэдээллийг дэвсгэрт тус

бүрээр харж болох сайн талтайг хурлаас тэмдэглэсэн байна. Мөнгөн тэмдэгтийг хэвлүүлэх зардал жилээс жилд өсч ирсэн боловч 2000 оноос огцом өссөн байна.

Мөнгөн тэмдэгт захиалж, үйлдвэрлүүлэх асуудалтай холбогдуулан Монголбанкны удирдагач доорх зөвлөмжийг хүргүүлэхээр тогтсон байна. Үүнд:

1. 2012 оноос эхлэн олон улсын хэмжээнд мөрддөг нийтлэг зарчмын дагуу мөнгөн дэвсгэртийг хэвлүүлэх нөхцөл, шаардлагыг нарийн тодорхойлох үндсэн дээр хаалттай, эсвэл нээлттэй тендер зарлаж, мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх компанийг сонгож байх зарчмыг баримталж ажиллах. Үүнтэй холбогдуулан мэргэжлийн болон хяналтын хүмүүсийн төлөөлөл оролцсон тендерийн тусгай хороог Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр байгуулж ажиллуулж байх;
2. Мөнгөн тэмдэгт захиалж үйлдвэрлүүлэх талаар гадаадын компанитай байгуулах гэрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, эсвэл түүний эрх олгосноор Тэргүүн дэд болон дэд Ерөнхийлөгч гарын үсэг зурж байх журамд шилжих;
3. Монголбанкны үйл ажиллагааны бие даасан хоёр чиглэлийг нэг газарт төвлөрүүлсэн нь бие биедээ харилцан хяналт тавьж ажиллах зарчимд нийцэхгүй байгааг харгалзан Монголбанкны удирдлагын бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний хүрээнд мөнгөн тэмдэгтийг захиалж хийлгэх, гүйлгээнд гаргахтай холбоотой асуудлыг хариуцсан бие даасан нэгжийг Монголбанкны бүтцэд бий болгохыг зөвлөмж болгосон байна.

Мөнгөн дэвсгэртийн нууцлалын хамгийн сүүлчийн үеийн найдвартай хэлбэр болох лазерийн аргаар дугаар тавих технологийг зарим том дэвсгэрт дээр хийлгэж, оронд нь үр дүн муутай, хэрэглэгч тэр бүр анхаардаггүй нууцлалыг хасах боломж байгааг судалж үзэх, мөнгөн тэмдэгтийн нууцлалын талаар хэрэглэгчид сурталчилж таниулах талаар Монголбанкаас өргөн хүрээтэй ажил тогтмол зохион байгуулах болон мөнгөн тэмдэгт хэвлүүлдэг Гиезеке энд Девриент компанийн зардлаар сургалтад хамрагдсан мөнгөн тэмдэгт тоолох, устгах машины ашиглалт хариуцсан ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах шаардлагатайг хурлаас тэмдэглэв.

Энэ хурлаар Эрсдэлийн удирдлагын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай Монголбанкны Эрсдэлийн удирдлагын алба, Дотоод аудитын газрын хамтарсан сонголыг хэлэлцэхээр төлөвлөсөн боловч дээрх албаны бэлтгэн оруулж ирсэн баримт бичиг, танилцуулга нь шаардлага хангаагүй тул уг асуудлыг энэ оны 12 дугаар сард болох ээлжит хурлаар дахин авч хэлэлцэхээр хойшуулсан байна.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ